



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/21

Булган сум

Хөрөнгө бүртгэлд авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Байгаль хамгаалах сан, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд ашиглалтад орсон барилга байгууламжийг данс бүртгэлд авах 2,492,117,600 (хоёр тэрбум дөрвөн зуун ерэн хоёр сая нэг зуун арван долоон мянга зургаан зуу) төгрөгийн хөрөнгийг хавсралтаар баталсугай. .

2.Хавсралтаар баталсан хөрөнгийг сум, байгууллагын данс бүртгэлд авч, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаж тайлагнахыг сумдын Засаг дарга, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, 2024 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай тооцоо нийлж баталгаажуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
 01 дүгээр сарын 10-ны/ний өдрийн 4/24 дүгээр
 захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ДАНС БҮРТГЭЛД АВАХ
 ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Үнийн дүн	Ашиглалтад хүлээн авах сум байгууллага	Гүйцэтгэгч компани	Хөрөнгийн эх үүсвэр
1	2	3	4	5	6
1	Нэгдсэн эмнэлгийн гадна зам талбайн засвар арчлалтын ажил	142,408,203	Нэгдсэн эмнэлэг	Энх-Алтаргана ХХК	Орон нутгийн төсөв
2	Рашаант сумын төвийн хатуу хучилттай авто зам	499,915,004	Рашаант сумын ЗДТГ	Энх-Алтаргана ХХК	Орон нутгийн хөгжлийн сан
3	Бугат сумын ЭМТ-ийн их засвар	297,900,000	Бугат сумын ЭМТ	Бүлээн Оргил ХХК	Орон нутгийн хөгжлийн сан
4	Музейн барилгын их засвар	359,000,000	Музей	Соотончоно ХХК	Орон нутгийн төсөв
5	Рашаант сумын төвийн гэрэлтүүлэг	46,486,949	Рашаант сумын ЗДТГ	Сайжрах шилтгээн ХХК	Орон нутгийн хөгжлийн сан
6	Сэлэнгэ сум Усан сан, цэвэр усны шугамын шинэчлэлийн ажил	673,261,921	Сэлэнгэ сумын ЗДТГ	Баатар шүтээн уул ХХК	Орон нутгийн төсөв
7	Хялганат тосгон Усан сан, цэвэр усны шугамын шинэчлэлийн ажил	330,604,147	Хялганат тосгон ЗАА	Сувдан ХХК	Байгаль хамгаала сан
8	Булган сум Ханжаргалант худалдааны төвөөс Хаан банк хүртэлх явган хүний замын ажил	142,541,376	Булган сум Тохжилт үйлчилгээний анги	Өвөлжөөн булаг ХХК	Орон нутгийн төсөв
Хөрөнгийн нийт дүн		2,492,117,600			